

3 ДУГААР АНГИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ БЛЮПРИНТ

2024.05.28

АНГИ, СУДЛАГДАХУУН		3 ДУГААР АНГИ, НЭГДМЭЛ								Нийт	Эзлэх хувь
ШАЛГАЛТ ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА		40 МИНУТ									
ДААЛГАВРЫН ХЭЛБЭР		СОНГОХ ДААЛГАВАР				ЗАДГАЙ ДААЛГАВАР					
Үнэлгээний нэгж	Суралцахуйн зорилт	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд	Мэдлэг ойлголт	Чадвар	Хэрэглээ	Бүгд		
Уншсанаа ойлгох	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	1/1			1/1					1/1	8.3%
		1/1			1/1					1/1	8.3%
			1/1		1/1					1/1	8.3%
Зохион найруулж бичих	3.4.а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яв?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх		1/1		1/1					1/1	8.3%
Уншсанаа ойлгох	3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах						1/2			1/2	8.3%
Зохион найруулж бичих	3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих							1/3		1/3	8.3%
Бүхэл тоо ба асуудал шийдвэрлэх	3.1а. 10000 хүртэлх натурал тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх	1/1			1/1					1/1	8.3%
Энгийн бутархай ба асуудал шийдвэрлэх	3.1г. 2, 3, 4, 5, 6, 8, 10 хуваарьтай энгийн бутархайг унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, ижил хуваарьтай энгийн бутархайг жиших, эрэмбэлэх		1/1		1/1					1/1	8.3%
Геометр ба асуудал шийдвэрлэх	3.3б. Куб, түүний дэлгээсийг таних, өгсөн дэлгээсээр нь бүтээх	1/1			1/1					1/1	8.3%
Өгөгдөлтэй ажиллах	3.4б. Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариулах	1/1			1/1					1/1	8.3%
								1/3		1/3	8.3%
Хэмжигдэхүүн ба асуудал шийдвэрлэх	3.2в. Нэгж квадратыг тоолж талбайн хэмжээг олох, талбайн хэмжээг сантиметр квадратаар илэрхийлэх; кубын дэлгээсийн талбайн хэмжээг олох								1/2	1/2	8.3%

ОНООНЫ ХЭВИЙН ТАРХАЛТ

Үнэлгээний зорилт	Даалгаврын тоо	Даалгаврын оноо	Даалгаврын эзлэх хувь	Онооны эзлэх хувь
Мэдлэг	5	5	41.6%	41.6 %
Чадвар	5	5	41.6%	41.6 %
Хэрэглээ	2	2	12.5	16 %
Нийт	12	12	100%	100%

3-Р АНГИЙН НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

№	Суралцахуйн зорилт	Танин мэдэхүйн түвшин	Авах оноо	Зөв хариу		Онооны тайлбар
				А хувилбар	Б хувилбар	
1	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	1	B	C	Зөв хариултыг сонгосон бол - 1оноо Хоёр сонголт хийсэн бол оноо өгөхгүй
2		Мэдлэг ойлголт	1	A	A	
3		Чадвар	1	B	C	
4	3.4.а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, явав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үсгийг олох, хэрэглэх	Чадвар	1	C	B	
5	3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах	Чадвар	2	- Бусдад сайхан сэтгэлээр хандаж, туслах - Ганц ч гэсэн сайхан үг хэлэх нь		Оновчтой 2 мэдээллийг олж бичсэн бол – 2 оноо Нэг мэдээллийг бичсэн бол – 1оноо
6	3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих	Хэрэглээ	3	Эхлэл, гол, төгсгөл хэсгийг гарган бичих (захидал бичсэн, ёсолсон, хүндэтгэсэн) Ашиглах үгс (талархсанаа, баярласан, сайхан сэтгэл)		Захидлыг бүтцийн дагуу, охины аавд хандан талархсан өнгө аястай бичсэн бол – 3 оноо Захидлыг бүтцийн дагуу талархсан өнгө аястай охины аавд хандаагүй бол – 1оноо
7	3.1а.10000 хүртэлх натурал тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, жишиг, эрэмбэлэх	Мэдлэг ойлголт	1	B	C	
8	3.1г. 2, 3, 4, 5, 6, 8, 10 хуваарьтай энгийн бутархайг унших, бичих, тоон шулуун дээр цэгээр тэмдэглэх, ижил хуваарьтай энгийн бутархайг жишиг, эрэмбэлэх	Чадвар	1	D	B	
9	3.3б. Куб, түүний дэлгээсийг таних, өгсөн дэлгээсээр нь бүтээх	Мэдлэг ойлголт	1	A	B	
10	3.4б. Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариулах	Мэдлэг ойлголт	1	B	A	Бүртгэл хийсэн, диаграммыг будсан, асуултад хариулсан бол тус бүр 0.5 оноо
11		Чадвар	3	Бүртгэл – цэнхэр- 3, шар – 7 Тэнцүү тоотой цэцэг – шар, улаан / ягаан/ Нийт цэцэг – 26	Бүртгэл – цэнхэр- 6, хөх-7 Тэнцүү тоотой цэцэг – шар, цэнхэр Нийт цэцэг – 30	
12	3.2в. Нэж квадратыг тоолж талбайн хэмжээг олох, талбайн хэмжээг сантиметр квадратаар илэрхийлэх; кубын дэлгээсийн талбайн хэмжээг олох	Хэрэглээ	2	Дүрсийн талбай 7см.кв = 7см.кв	Дүрсийн талбай 5см.кв > 4см.кв	Дүрсийн талбайг зөв тооцоолсон бол 1оноо Зөв жишсэн бол 1оноо
	БҮГД		18			

3 ДУГААР АНГИЙН НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хугацаа 40 мин

2024.05.28

..... сургуулийн ангийн сурагч

А хувилбар

МОНГОЛ ХЭЛ Даалгавар бүрийн зааврыг анхааралтай уншиж зааврын дагуу бүрэн гүйцэтгэх Аз жаргалыг хэн түгээх вэ?

Тоглоомын талбайд нэгэн охин аавыгаа хүлээн өөрийн гараар зурж наасан мэндчилгээ бариад сууж байв. Удалгүй ажлын хувцастай, толгойдоо хамгаалалтын малгай өмссөн аав нь булан тойроод гараад ирлээ. Охин аавдаа гүйн тэврүүлээд, хийсэн бүтээлээ үзүүлэн магтуулж, бөөн баяр болов. Харин өөр нэгэн хүү үүнийг харж суулаа. Аав нь гадаадад яваад удсан юм. Хүүхдүүдийн аавыг хараад жаал аавыгаа илүү их санана. Уйлах шахан доош харахыг нь өнөө охины аав анзаарчээ. Тэгээд “Өнөрөө, миний дүү ахаараа зайрмаг авахуулах уу?” гэж хүүгээс асуухад хүүгийн нүд сэргээд ирлээ. Тэр сайхан сэтгэлт аав хоёр хүүхдэд зайрмаг авч өгөөд, “Аав нь бас чамайг санаад, ингэж зайрмаг авч өгөхийг хүсэж байгаа даа. Тэгэхээр удахгүй ирэх л ёстой доо” гэв. Хүүгийн сэтгэлд “Аав удахгүй ирнэ” гэсэн аз жаргалтай бодол гэрэлтэж байлаа. Бид хүүхэд ч байсан, томчууд ч байсан ялгаагүй бусдад сайхан сэтгэлээр хандаж, ганц ч гэсэн сайхан үг хэлэх нь аз жаргалыг түгээж байгаа хэрэг юм.

Сонгох даалгаврын зөвхөн нэг л хувилбарыг сонгоорой. Сонгох хариутай даалгавар бүр 1 оноотой.

1. Эхэд хэн хэн гарсан бэ?

- A. Аав, ээж, охин
- B. Охин, аав, Өнөрөө
- C. Хүү, охин, хүүхэд

2. Хүүг хэн баярлуулсан бэ?

2. Хүү яагаад аавыгаа их санасан бэ?

- A. Аав нь гадаад яваад удсан.
- B. Аав нь цэрэгт яваад удсан.
- C. Аав нь хөдөө яваад удсан.

3. Хүүгийн-д “Аав удахгүй ирнэ” гэсэн аз жаргалтай гэрэлтэж байлаа.

- A. Саннаа, сэтгэл
- B. Сэтгэл, бодол
- C. Хүсэл, бодол

4. Өгүүлбэрт тодруулсан үгсэд тохиорох асуултыг олоорой.

Хүүгийн сэтгэлд “Аав удахгүй ирнэ” гэсэн аз жаргалтай бодол гэрэлтэж байлаа..

А. юу ямар ? B. ямар яах ? C. ямар юу ?

5. Аз жаргалыг түгээж байгаа хэрэг гэж юу болохыг илэрхийсэн хэсгийг ялган бичээрэй. /2 оноо/

ХОЁР: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР:

Дээрх “Аз жаргалыг хэн түгээх вэ?” эхийг ашиглан, охины аавд хандан талархлын захидал бичээрэй. Захидлыг бичихдээ зөв бичих дүрмийн алдаагүй, хичээнгүй бичиж гүйцэтгээрэй. Үгийн тоо – 50 Захидал бичихдээ ашиглах үгс: / талархсанаа, баярласан, сайхан сэтгэл / 3 оноо

МАТЕМАТИК Даалгавар бүрийн зааврыг анхааралтай уншиж зааврын дагуу бүрэн гүйцэтгээрэй.

1. “Хоёр зуун далан таван мянга хорин дөрөв” гэсэн тооны бичлэг аль нь вэ?


- A. 275 004 B. 275 024 C. 270 024 D. 270 524


2. Туузыг тэнцүү хэсэгт хуваажээ. Энгийн бутархайд харгалзах хэсгийг будсан туузыг олоорой.

$$\frac{7}{10}$$


A. 

B. 

C. 

D. 

3. Кубийн дэлгээс бүтээж болох дүрсүүдийг сонгон - ээр тэмдэглээрэй



4. Сурагчдын зурсан дүрсийн тоог хүснэгтээр харуулав. Үжингийн зурсан дүрсийн тоог олоорой.

Марал	
Очир	
Ганаа	
Үжин	


 - 100

- A. 400 B. 450 C. 650 D. 500

5. Цэцгийн тоог хүснэгтэд бүртгэж, дүрслэн будаад, асуултад хариулаарай. / Зоноо /




Цэцэг	Зураас	Ширхэг
		4
		
		
		5
		7



Тэнцүү тоотой ямар цэцгүүд байна вэ?

Нийт хэдэн цэцэг байна вэ?

6. Дүрсийн талбайг тооцоолоод, жишээрэй. (1 см.кв = 4нүд) / 20ноо /



3 ДУГААР АНГИЙН НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хугацаа 40 мин

2024.05.28

..... сургуулийн ангийн сурагч

Б хувилбар

МОНГОЛ ХЭЛ Даалгавар бүрийн зааврыг анхааралтай уншиж зааврын дагуу бүрэн гүйцэтгэх Аз жаргалыг хэн түгээх вэ?

Тоглоомын талбайд нэгэн охин аавыгаа хүлээн өөрийн гараар зурж наасан мэндчилгээ барид сууж байв. Удалгүй ажлын хувцастай, толгойдоо хамгаалалтын малгай өмссөн аав нь булан тойроод гараад ирлээ. Охин аавдаа гүйн тэврүүлээд, хийсэн бүтээлээ үзүүлэн магтуулж, бөөн баяр болов. Харин өөр нэгэн хүү үүнийг харж суулаа. Аав нь гадаадад яваад удсан юм. Хүүхдүүдийн аавыг хараад жаал аавыгаа илүү их санана. Уйлах шахан доош харахыг нь өнөө охины аав анзаарчээ. Тэгээд “Өнөрөө, миний дүү ахаараа зайрмаг авахуулах уу?” гэж хүүгээс асуухад хүүгийн нүд сэргээд ирлээ. Тэр сайхан сэтгэлт аав хоёр хүүхдэд зайрмаг авч өгөөд, “Аав нь бас чамайг санаад, ингэж зайрмаг авч өгөхийг хүсэж байгаа даа. Тэгэхээр удахгүй ирэх л ёстой доо” гэв. Хүүгийн сэтгэлд “Аав удахгүй ирнэ” гэсэн аз жаргалтай бодол гэрэлтэж байлаа. Бид хүүхэд ч байсан, томчууд ч байсан ялгаагүй бусдад сайхан сэтгэлээр хандаж, ганц ч гэсэн сайхан үг хэлэх нь аз жаргалыг түгээж байгаа хэрэг юм.

Сонгох даалгаврын зөвхөн нэг л хувилбарыг сонгоорой. Сонгох хариутай даалгавар бүр 1 оноотой.

1. Хүү хэнийг их санасан бэ?

- A. Найзыгаа
- B. Ээжийгээ
- C. Аавыгаа

2. Хүүг хэн баярлуулсан бэ?

- A. Охины аав баярлуулсан
- B. Хүүгийн аав баярлуулсан.
- C. Охин баярлуулсан

3. Хүүгийн-д “Аав удахгүй ирнэ” гэсэн аз жаргалтай гэрэлтэж байлаа.

- A. Хүсэл, бодол
- B. Санаа, сэтгэл
- C. Сэтгэл, бодол

4. Өгүүлбэрт тодруулсан үгсэд тохирох асуултыг олоорой.

Бид хүүхэд ч байсан, томчууд ч байсан ялгаагүй бусдад сайхан сэтгэлээр хандаж, ганц ч гэсэн сайхан үг хэлэх нь **аз жаргалыг түгээж** байгаа хэрэг юм.

А. яаж юуг ? B. юуг яаж ? C. юуг яасан ?

5. Аз жаргалыг түгээж байгаа хэрэг гэж юу болохыг илэрхийсэн хэсгийг ялган бичээрэй. /2 оноо/

ХОЁР: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР:


Дээрх “Аз жаргалыг хэн түгээх вэ?” эхийг ашиглан, охины аавд хандан талархлын захидал бичээрэй. Захидлыг бичихдээ зөв бичих дүрмийн алдаагүй, хичээнгүй бичиж гүйцэтгээрэй. Үгийн тоо – 50 Захидал бичихдээ ашиглах үгс: / талархсанаа, баярласан, сайхан сэтгэл / 3 оноо

МАТЕМАТИК Даалгавар бүрийн зааврыг анхааралтай уншиж зааврын дагуу бүрэн гүйцэтгээрэй.


1.“Дөрвөн зуун жаран таван мянга хорин дөрөв” гэсэн тооны бичлэг аль нь вэ?

- A. 465 004 B. 465 204 C. 465 024 D. 465 524

2. Түүзыг тэнцүү хэсэгт хуваажээ. Энгийн бутархайд харгалзах хэсгийг будсан түүзыг олоорой.



3. Кубийн дэлгээсийг олж – ээр тэмдэглээрэй.



4. Сурагчдын тарьсан модны тоог хүснэгтээр харуулав. Очирын тарьсан модыг олоорой.

Марал	
Очир	
Ганаа	
Үжин	


- 100

- A. 650 B. 350 C. 550 D. 450

5. Цэцгийн тоог хүснэгтэд буртгэж, дурслэн будаад, асуултад хариулаарай.



Цэцэг	Зураас	Ширхэг
		4
		
		7
 <u>_____</u>		6
		



Нийт хэдэн цэцэг байна вэ?

Тэнцүү тоотой ямар цэцгүүд байна вэ?

6. Дүрсийн талбайг тооцоолоод, жишээрэй. (1см.кв = 4нүд)

